

“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 4-р сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2021 оны 4-р сарын 9-ний өдөр компанийн өөрийн байрны 3 давхарт байрлах хурлын танхимд 15.00 цагаас хосолсон хэлбэрээр болж өнгөрлөө. Хурлын ирцийн бүртгэлийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс явууллаа. Хурлыг хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн нээж үг хэллээ.

Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцож байгаа хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа. Намайг Д.Эрдэнэсүрэн гэдэг би энэ компанид Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажилладаг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хурал зохион байгуулах комиссын даргаар ажиллаж байна. Ингээд та бүхэнд хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулья.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалд хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэг байгаа болно. Хэлэлцэх асуудал үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
2. Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
3. Компанийн 2019 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийн тухай
4. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
5. Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилтын тухай
6. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж батлах тухай
7. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай
8. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай

Хурлын дэгийн дагуу хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай мэдээллийг та бүхэнд танилцуулья. Манай Компанийн дүрмийн 7.5-р заалтын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга”-аар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга байна гэсэн заалтыг үндэслэн хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Оюунсүрэн удирдан явуулна. .

Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг бүртгэж байгаа тооллогын комиссоос хурлын ирцийн талаарх мэдээллийг ирүүлсэн бөгөөд хурлын ирц 15:00 цагийн байдлаар 85.68 хувьтай байна. Нийт 982 хувьцаа эзэмшигчдээс 6 хувьцаа эзэмшигч танхимаар, 2 хувьцаа эзэмшигч цахимаар оролцлоо. Брокер диллерийн компаниудаас саналын хуудас ирсэнгүй. Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хурлын ирцийг хангалттай гэж үзээд, хурал нээснийг мэдэгдэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Д.Оюунсүрэн ээлжит хурлыг нээв.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Компанийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцож буй та бүхэндээ баярлалаа. Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн та бүхэнд хурлаар

хэлэлцэх асуудлын жагсаалт болон хурлын дэг, хурлын ирцийг танилцууллаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хангалттай тул хуралдаа орцгооё. Хэлэлцэж байгаа асуудал тус бүр дээр хувьцаа эзэмшигчид та бүхэн саналаа илэрхийлнэ үү.

1. Хэлэлцсэн асуудал: Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн тухай. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Сайн байцгаана уу эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчдээ, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хуралдаа танхимаар болон цахимаар оролцож буй та бүхэндээ компанийн гүйцэтгэх удирдлагын өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье. Тус компани нь өнгөрсөн 2020 онд батлагдсан орлого, зарлагын төсөв төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Үйл ажиллагааны тухай:

- Худалдааны төвийн захиргаа нь давхардсан тоогоор 200 гаруй түрээслэгч аж ахуйн нэгж, иргэдтэй 2020 онд түрээсийн гэрээ байгуулан ажилласан. Худалдааны төвийн нийт түрээслэгчдийг бараа материалын даатгалд бүрэн хамруулсан. Түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж, цар тахлын үед хэрхэн ажиллах, халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн баримтлах талаарх зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч, харилцан ойлголцож ажиллалаа.
- Худалдааны төвийн нийт түрээслэгчидтэй байгуулсан гэрээнд “Түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээ”-г шинээр бий болгож, түрээслэгчдийн бизнесийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, түрээсийн гэрээ, дотоод журмын хэрэгжилтийг сайжруулах, түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг түрээслэгч тус бүрт ялгавартай үзүүлдэг аргачлалыг нэвтрүүллээ.
- Дэлхийн нийтийг хамарсан коронавирусын халдварт өвчний үед худалдааны төв хэрхэн ажиллах талаарх зөвлөмжийг боловсруулан гаргаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллалаа. Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисс, Мэргэжлийн хяналтын газраас гаргасан заавар журмыг худалдааны төвийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллалаа. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж, түрээслэгч, худалдан авагч, ажиллагсдын QR кодын бүртгэлийг өдөр тутамд хийж заншлаа.
- ЗГ, УОК-ын шийдвэрээр “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжиж, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон 2020 оны 3-р сарын 6 өдрийн түрээсийн төлбөрт 100%-ийн хөнгөлөлт, 2020 оны 11, 12-р сарын 29 өдрийн түрээсийн төлбөрт 70%-ийн хөнгөлөлтийг тус тус үзүүлсэн. Өнгөрсөн 2020 онд манай худалдааны төв нийт 35 өдөр ажиллалаагүй болно.
- Худалдааны төвийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд хийгддэг урсгал засвар, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэлээ.
- Нийслэлийн газрын албатай “Тазар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ”-ний үүргийн хэрэгжилтийг дүгнүүлж, газар эзэмших гэрээг 15 жилийн хугацаатай байгууллаа.
- Хөндлөнгийн аудитын “Цэсб аудит” ХХК-тай гэрээ байгуулж, компанийн санхүүгийн тайланд хяналт шалгалтын ажлыг хийлгэлээ.
- Нийслэлийн болон БГД-ийн цагдаагийн хэлтэстэй хамтран халаасны хулгай, цахим гэмт хэрэг, залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, сурталчилгааны ажлыг түрээслэгчдийн дунд явууллаа.
- БГД-ийн Онцгой байдлын хэлтсээс 2020 оны галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг гаргуулан авсан бөгөөд худалдааны төвийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, дүүргийн Онцгой байдлын хэлтсээр хянуулан баталгаажуулсан.

- Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль, эрх зүйн заавар журмын дагуу компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг СЗХороонд цаг хугацаанд нь хүргүүлж, МХБиржийн сайт болон өөрийн компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж ирлээ.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлуудыг зарлан хуралдуулах бэлтгэл ажлыг холбогдох хууль, дүрмийн дагуу зохион байгуулж ажилласан.

Санхүүгийн тайлангийн тухай

1. Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай : Компанийн нийт хөрөнгө 8 480.6 сая төгрөг бөгөөд үүнээс :
 - Эргэлтийн хөрөнгө 2 114.8 сая төгрөг
 - Үндсэн хөрөнгө 4 077.3 сая төгрөг
 - Биет бус хөрөнгө 2 288.5 сая төгрөг
 - Эзэмшигчийн өмч хөрөнгө 8 234.7 сая төгрөг
 - Татварын дараах цэвэр ашиг 910.6 сая төгрөг байна.
2. Татварын өр төлбөрийн тухай: Манай компани 2020 онд улсад нийт 353.7 сая төгрөгийн татварыг төлсөн байна. Үүнд:
 - ААН-ийн ОАТатварт 57.0 сая төгрөг
 - НДШимтгэлд 30.4 сая төгрөг
 - ХХОАТатварт 12.4 сая төгрөг
 - НӨАТатварт 142.4 сая төгрөг
 - ҮХЭХАТатварт 36.1 сая төгрөг
 - Ногдол ашгийн татварт 63.6 сая төгрөг
 - Газрын төлбөрт 11.8 сая төгрөг
3. Орлогын үр дүнгийн тухай : Компани 2020 онд 1 540.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 1 621.6 сая төгрөг байсантай харьцуулахад гүйцэтгэл 94.98%-ийн биелэлттэй байна. Орлогыг төсөвлөснөөс 81.4 сая төгрөгөөр тасалдуулсан бөгөөд дэлхий нийтээр тархсан коранавирусын цар тахлын улмаас ЗГ, УОК-ын шийдвэрээр манай худалдааны төв нийт 35 өдөр хаагдаж, түрээсийн орлого тасалдсан болно. Хадгаламжийн хүүний орлогын төлөвлөгөө 200.0 сая төгрөг байсан, гүйцэтгэл 206.5 сая төгрөг болж, төлөвлөгөөг 103.23% буюу 6.5 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.
4. Зардлын тухай : Компанийн хэмжээгээр 2020 онд 735.0 сая төгрөгийн зардал гарсан болно. Зардлын төлөвлөгөө 832.6 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 88.3%-ийн биелэлттэй гарсан. Компанийн хэмжээгээр зардлыг төсөвлөснөөс 97.6 сая төгрөгөөр хэмнэж ажилласан болно. Хэмнэсэн зардал нь төр засгаас ковид19 цар тахлын үед НДШ-ийг 6 сарын турш хөнгөлсөн, мөн ажиллалаагүй үеийн ашиглалтын зардлууд хэмнэгдсэнтэй шууд холбоотой болно.
5. Ашгийн тухай : Компанийн хэмжээгээр 2020 онд 910.6 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Ашгийн төлөвлөгөө 890.2 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 102.3%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 20.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ 11 төгрөг 59 мөнгө гарсан. 2020 оны нэгж хувьцаанд ногдох ашгийн төлөвлөгөө 11 төгрөг 33 мөнгө байсантай харьцуулахад


төлөвлөгөөний биелэлт 102.3%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 26 мөнгөөр давуулан биелүүлсэн.

Тус компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс хэрэгжүүлэн ажилласан 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөл хангалттай сайн гэж дүгнэсэн болно. Дараах хүснэгт слайдаар компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг гаргаж тавьсан.


Санхүүгийн үзүүлэлт : Компанийн 2016 - 2020 он хүртэлх сүүлийн 5 жилийн эдийн засгийн ерөнхий судалгааг шинэчлэн гаргасныг хувыцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Эргэлтийн хөрөнгө	1,541,179,226.10	1,678,326,249.34	1,721,276,038.37	1,874,201,189.91	2,114,796,356.89
2	Эргэлтийн бус хөрөнгө	6,861,584,941.56	6,805,624,589.59	6,677,378,101.86	6,527,354,400.69	6,365,855,327.44
3	Нийт хөрөнгө	8,402,764,167.66	8,483,950,838.93	8,398,654,140.23	8,401,555,590.60	8,480,651,684.33
4	Нийт өр төлбөр	209,455,277.50	198,987,075.45	213,651,174.42	206,660,096.80	245,942,546.49
5	Эзэмшигчдийн өмч	8,193,308,890.16	8,284,963,763.48	8,185,002,965.81	8,194,895,493.80	8,234,709,137.84
6	Борлуулалтын орлого	1,367,696,294.36	1,334,591,010.34	1,389,183,726.83	1,449,256,652.85	1,540,194,398.62
7	Нийт орлого	1,489,906,907.10	1,490,397,917.45	1,572,606,312.34	1,652,538,682.76	1,746,874,233.59
8	Нийт зардал	817,376,753.65	774,988,602.67	789,189,311.26	832,528,421.60	836,238,153.28
9	Нийт ашиг	750,829,448.23	794,898,101.23	870,464,204.26	911,677,442.26	1,011,817,561.55
10	Цэвэр ашиг	672,530,153.45	715,409,314.78	783,417,870.81	820,010,261.16	910,636,080.31
11	EPS /Нэгж хувыцаанд ногдох ашиг/	8.56	9.11	9.97	10.44	11.59
12	PE /Үнэ ашгийн харьцаа/	19.84	15.59	14.04	12.45	11.13
13	ROE /Хувыцаат капиталын өгөөж/	0.08	0.09	0.10	0.10	0.11
14	BV /Нэгж хувыцаанд ногдох дансны үнийн харьцаа/	1.70	1.42	1.40	1.30	1.29


НИЙТ ХӨРӨНГӨ /САЯ.ТӨГ/




ОРЛОГО, ЗАРЛАГА, ЦЭВЭР АШИГ /сая.төг/




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая.төг/




ЦЭВЭР АШГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая.төг/



НИЙТ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая.төг/




ОРЛОГЫН БҮТЭЦ-2020 ОН /Нийт 1,746.7 сая төгрөг/




Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Графикаас харвал 2020 онд орлогын төлөвлөгөө 81.4 сая төгрөгөөр тасалдсан нь коронавирусын халдварт өвчний дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан ЗГ, УОК-оос “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбогдуулан худалдааны төвийн үйл ажиллагааг нийт 35 хоног хааж, түрээсийн орлого тасалдсантай шууд холбоотой юм.

НИЙТ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая.төг/




ЗАРДЛЫН БҮТЭЦ 2020 ОН /НИЙТ 836.2 САЯ ТӨГРӨГ/




Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Компанийн хэмжээгээр зардлыг төсөвлөснөөс 97.6 сая төгрөгөөр хэмнэж ажилласан бөгөөд энэ нь төр засгаас ковид19 цар тахлын үед НДШ-ийг 6 сарын турш хөнгөлсөн, мөн ажиллалаагүй үеийн ашиглалтын зардлууд хэмнэгдсэнтэй шууд холбоотой болно.

ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР /сая.төгрөг/




НИЙТ ХӨРӨНГӨНД ӨР ТӨЛБӨРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ 2020 ОН




■ Нийт хөрөнгө - 97.1% ■ Өр төлбөр - 2.9%


НИЙТ ТӨЛСӨН ТАТВАР /сая.төг/




КОМПАНИЙН НИЙТ ОРЛОГЫН ХЭМЖЭЭ /сая.төг/



КОМПАНИЙН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ /сая.төг/



КОМПАНИЙН ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ /сая.төг/



Мөн компанийн сүүлийн 5 жилийн түрээсийн төлбөрийн үнэ тарифыг харьцуулсан судалгааг хувыцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

№	Талбайн нэр	Хэмжих нэгж	Огноо / Түрээсийн үнэ тариф				
			2017	2018	2019	2020	2021
1	1-р давхрын павильон	м.кв	20 000	20 000	20 000	20 000 (+), (-)	20 000 (+), (-)
2	С давхрын павильон	м.кв	17 000	17 000	18 000	20 000 (+), (-)	20 000 (+), (-)
3	2-р давхрын павильон	м.кв	17 000	17 000	18 000	20 000 (+), (-)	20 000 (+), (-)
4	Оффис үзүүлэнгийн талбай	м.кв	17 000	17 000	18 000	20 000 (+), (-)	20 000 (+), (-)
5	Лангуу	ш	150 000	150 000	150 000	200 000	200 000


Энэхүү судалгаанаас үзэхэд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 онд С давхар, 2-р давхар, оффисын 1м.кв талбайн үнийг 2 000 төгрөгөөр, контейнэр, лангууны 1 сарын түрээсийн үнэ тарифыг 50 000 төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан. Харин 2021 онд түрээсийн үнэ тарифын тогтвортой бодлогыг баримталж ажиллана. Энэ бодлогод манай худалдааны төвийн түрээслэгчид 100% сэтгэл хангалуун байгаа бөгөөд одоогоор түрээсийн төлбөрийн ямар нэгэн хуримтлагдсан өр авлагагүй ажиллаж байна. Мөн 2020 оноос эхлэн худалдааны төвийн түрээслэгчидтэй байгуулсан түрээсийн гэрээг “Түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээ”-гээр жилийн эцэст нэг удаа үнэлдэг болсон бөгөөд үнэлгээний дүнгээс хамааруулан дараа жилийн 1, 2-р саруудын түрээсийн төлбөрт 0% - 10%-ийн хөнгөлөлтийг ялгавартайгаар үзүүлдэг болсон.

Хувыцаа эзэмшигч М.Шигшээ: Кобид19 цар тахлын энэ үед түрээслэгчдэдээ түрээсийн хөнгөлөлт үзүүлж байгаа юу?


Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: ЗГ, УОК-ын шийдвэрээр “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжиж, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон 2020 оны 3-р сарын 6 өдрийн түрээсийн төлбөрт 100%-ийн хөнгөлөлт, 2020 оны 11, 12-р сарын 29 өдрийн түрээсийн төлбөрт 70%-ийн хөнгөлөлтийг тус тус үзүүлсэн бөгөөд 2021 онд түрээслэгчидтэй байгуулсан түрээсийн гэрээнд аливаа гамшгийн үед түрээсийн төлбөрт 60 хувийн хөнгөлөлтийг үзүүлж, 40 хувийн түрээсийн төлбөрийг авахаар болсон. Учир нь харуул хамгаалалт, газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн татвар, ажиллагсдын цалин хөлс гэх мэт зардлууд тогтмол гарсаар байгаатай холбоотой юм. Энэ асуудлыг манай ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж баталсан.

Хувыцаа эзэмшигч М.Шигшээ: За баярлалаа. Ил тод, дэлгэрэнгүй, ойлгомжтойгоор тайлангаа танилцуулж буй гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэгтээ баярлалаа. Асуусан асуултандаа маш тодорхой, ойлгомжтой хариулт авч чадлаа.


Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Манай хамгийн идэвхитэй хувьцаа эзэмшигчдийн нэг бол хувьцаа эзэмшигч М.Шигшээ байгаа. Хувьцаа эзэмшигч М.Шигшээдээ хуралдаа байнга тогтмол оролцож, санал бодлоо илэрхийлж байдаг баярлалаа. Манай "Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол ашиг тараадаг компаниудын нэгэн бөгөөд 2010 - 2020 он хүртэл тараасан ногдол ашгийг хэмжээг дараах графикаас харна уу.



Дээрх график, судалгаанаас үзвэл манай компанийн ногдол ашгийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдсэн байгааг та бүхэн харж байна. Мөн нэгж хувьцаанд оногдох ашгийн хэмжээ, нэгж хувьцаанд оногдох ашгийн төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 5 жилээр харьцуулсан судалгааг дараах графикаар харуулав.



НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /төгрөг/




Судалгаанаас үзвэл мөн л нэгж хувьцаанд оногдох ашгийн хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан байна.

Хувьцааны зах зээлийн үнэлгээ


"Гермес Центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээр 2 дугаар ангиллын компанид багтдаг бөгөөд 2020 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлийн үнэлгээ 10.1 тэрбум төгрөг болсон .

Хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэгж хувьцааны анхны ханш 2010 онд 54 ₮ байсан бол 2020 онд нэгж хувьцааны ханш 129 ₮ болсон бөгөөд дараах графикаар хувьцааны ханшийн өөрчлөлтийг харуулав.



Хувьцаа эзэмшигчдийн тухай:



Компанийн 2020 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр буюу 2021 оны 03-р сарын 11-ний өдрөөр тасалбар болгосон жагсаалтаас үзэхэд нийт 78 543 001 ширхэг хувьцааны 42 530 145 ширхэг буюу 54.15 хувийг иргэн Д.Зоригт, 23 460 015 ширхэг буюу 29.87 хувийг иргэн Д.Оюунсүрэн, 3 777 571 ширхэг буюу 4.81 хувийг “Импера Монголиа” ХХК, 8 775 270 ширхэг буюу 11.17 хувийг бусад хувьцаа эзэмшигч нар эзэмшиж байгааг харж болно. Хувьцаа эзэмшигч та бүхэнд миний тавьсан тайлангаас асууж тодруулах зүйл байна уу?

Хурлын дарга Д.Оюунсүрэн : Компанийн засаглалын талаар тайланд бэлтгэсэн материалаа танилцуулна уу.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг : Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний хувьд та бүхэндээ өөрийн компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар танилцуулъя. Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу манай компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байдаг. Хувьцаа эзэмшигч та бүхэн дараах слайднаас манай компанийн засаглалын бүтцийг харна уу. Манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд Компанийн дүрмийн дагуу 5 жилийн хугацаагаар сонгогдон ажилладаг. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь дэргэдээ Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо гэсэн 3 дэд хороог ажиллуулдаг. Хараат бус 3 гишүүнтэй, жирийн 6 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Дарга Д.Оюунсүрэн

Гүйцэтгэх захирал
Б.Оюунцэцэг
Нягтлан бодогч О.Энхтуяа
ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга Д.Эрдэнэсүрэн

АУДИТЫН
ХОРОО

Д.Туяа
Н.Батсайхан
Б.Алтангэрэл

ЦАЛИН
УРАМШУУЛЛЫН
ХОРОО

Д.Оюунсүрэн
Д.Алтанчимэг
Н.Мөнхзул

НЭР ДЭВШҮҮЛЭХ
ХОРОО

Б.Оюунцэцэг
Ц.Түвшинжаргал
Б.Амарсанаа

Манай компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өнгөрсөн жилийн хугацаанд улирал тутамд буюу танхимаар 3 удаа, цахим хэлбэрээр 1 удаа хуралдаж, нийт 4 удаа ээлжит хурлаа хийж, бүгд 23 төрлийн тогтоол шийдвэрүүдийг гаргаж баталсан бөгөөд тэдгээр шийдвэрүүд нь хэрэгжиж биелэгдсэн. Үүнд:

- Компанийн 2019 оны сүүлийн хагас жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг баталсан
- Компанийн 2019 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан
- Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийг дүгнэсэн
- Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг хуралдуулсан
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга болон хурал зохион байгуулах комиссыг томилсон
- Тооллогын комиссыг баталсан
- Компанийн 2020 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийх компанийг сонгож баталсан
- “Термес худалдааны төвд коронавирусын халдварт өвчний сэжигтэй тохиолдлын үед авах арга хэмжээний зөвлөмж”-ийг хэлэлцэж баталсан
- Түрээслэгчидтэй байгуулсан түрээсийн гэрээг үнэлэх “Түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээ”-г баталж хэрэгжүүлсэн
- Компанийн 2020 оны эхний хагас жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг баталсан
- Компанийн 2020 оны эхний хагас жилийн цэвэр ашгийг хуваарилсан
- Компанийн 2020 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан

- “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжсэнтэй холбогдуулан түрээслэгчдэд үзүүлэх түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлсэн
- Гермес худалдааны төвийн 2021 онд баримталж ажиллах түрээсийн үнэ тарифыг баталсан
- Гермес худалдааны төвийн түрээслэгчидтэй байгуулах “Түрээсийн гэрээ” болон тэдгээрийн мөрдөж ажиллах дотоод журмыг шинэчлэн баталсан
- “Гермес Центр” ХК-ийн 2021 оны ажиллагсдын орон тоо, цалингийн төсвийг баталсан
- “Гермес худалдааны төв”-ийн ажил, амралтын өдрийг баталсан
- “Гермес Центр” ХК-ийн 2021 оны орлого, зарлагын төсвийг баталсан
- “Гермес Центр” ХК-ийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсвийг баталсан

Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлын тухайд компанийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн хурлаас баталсан 5 тоот тогтоолын дагуу гүйцэтгэх удирдлагын баг бэлтгэл ажлыг хангаж, хурлын зарыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу өдөр тутмын сонин, телевиз, радио, мөн өөрийн компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн сайтаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, үнэт цаасны компаниудад цахим шуудангаар хурлын материалын хамт хүргүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос дэлхий нийтэд эрчимтэй тархаж буй “Covid 19” өвчнөөс урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдлийг бууруулах зорилгоор хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тухай чиглэлийг компаниудад өгсөн. Үүний дагуу хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг 2020 оны 03-р сарын 20-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хурлын ирц 85.74 %-тай байсан бөгөөд хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан. Үүнд:

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
- Компанийн 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
- Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2020 оны ногдол ашгийн тухай
- Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
- Компанийн 2020 оны зорилтын тухай

Бидний зүгээс компанийн ХЭХурал, ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол шийдвэрүүдийг Компанийн тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагаас баталж гаргасан заавар, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлсээр ирсэн. Мөн өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэдээ мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна. Ингээд хувьцаа эзэмшигч та бүхэнд миний тавьсан тайлан илтгэлээс асууж тодруулах зүйл байвал асууна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мөн компанийн сүүлийн 5 жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг багтаасан судалгаатай холбогдуулан асуух асуулт байхгүй, ойлгомжтой байна гэв.

Хэлэлцсэн 1-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан тэмдэглэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу 2-р асуудалдаа орцгооё.

**2. Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт:
Хэлэлцүүлэгч Аудитын хорооны дарга: Д.Туяа**

Аудитын хорооны дарга Д.Туяа: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хуралдаа оролцож буй хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа.

Манай компани нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “ЦЭСБ АУДИТ”ХХК-иар санхүүгийн тайландаа аудит хийлгээд 5 дахь жилдээ орж байна.

Аудитын компани нь “Гермес Центр” Хувьцаат компанийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүү байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын ажлыг хагас жил тутамд хийж гүйцэтгэсэн. “Цэсб аудит” ХХК нь “Гермес Центр” ХК-ийн тухайн жилийн санхүүгийн тайлангуудын бүхий л үзүүлэлтүүд нь материаллаг асуудлаар Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулагдсан байна” гэж дүгнэсэн. Компанийн аудитын хороо энэхүү дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, сайшаан тэмдэглэсэн болно.

Манай компанийн аудитлагдсан санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудын үндсэн үзүүлэлтүүдийг багтаасан дэлгэрэнгүй тайланг сая Гүйцэтгэх захирал та бүхэнд танилцууллаа. Ингээд Аудитын хорооноос асууж тодруулах зүйл байвал асууна уу.

Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс хэлэлцсэн 2-р асуудалтай холбоотой асуух асуулт байхгүй гэсэн тул дэгийн дагуу дараагийн асуудалдаа орцгооё.

- **Хэлэлцсэн 2-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшааж, хурлын тэмдэглэлд оруулав.**

3. Компанийн 2019 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийн тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

Хурлын дарга Д.Оюунсүрэн : Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг болон Аудитын хороо Д.Туяа нартаа баярлалаа. Ингээд хувьцаа эзэмшигч та бүхэндээ Компанийн тухай хуулийн дагуу 2019, 2020 оны ногдол ашгаа хэрхэн тараасан, мөн хэрхэн хуваарилсан, бас цаашид ногдол ашгаа хэрхэн хуваарилах талаарх мэдээллийг хүргэе.

Манай компани нь 2019 оны эхний хагас жилд 5 төгрөг 70 мөнгө буюу 447.7 сая төгрөг, мөн оны сүүлийн хагас жилд 4 төгрөг 10 мөнгө буюу 322.0 сая төгрөг, нийт 769.6 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилсан. Нэгж хувьцаанд 9 төгрөг 80 мөнгөний ногдол ашиг олгосон байна.

Харин 2020 оны эхний хагас жилд 6 төгрөг 60 мөнгө буюу 518.4 сая төгрөг, мөн оны сүүлийн хагас жилд 4 төгрөг 80 мөнгө буюу 377.0 сая төгрөг, нийт 895.4 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилсан. Нэгж хувьцаанд 11 төгрөг 40 мөнгөний ногдол ашиг олгоод байна.

Мөн манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2021 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, 2021 оны санхүүгийн тайланд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр хоёр удаа хуваарилах саналтай байгааг хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдэхэд таатай байна.

Ингээд хувьцаа эзэмшигч та бүхэн дэлгэцэн дээр гарч байгаа 2019 болон 2020 оны ногдол ашиг тараалтын тайланд анхаарлаа хандуулна уу.

Ногдол ашиг зарласан огноо		Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (төг)	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Нийт ногдол ашгийн дүн (төг)	Ногдол ашиг олгосон хэлбэр		Ногдол ашиг тараалтын хувь
					Компани дээр бэлнээр	ҮЦТХТөв өөр бэлэн бусаар	
2019	Эхний хагас жил	5.7	937	447.7 сая	384.2 сая	63.5 сая	100%
	Сүүлийн хагас жил	4.1	961	322.0 сая	276.2 сая	45.8 сая	100%
Нийт		9.8		769.7 сая			
2020	Эхний хагас жил	6.6	962	518.4 сая	444.1 сая	74.3 сая	100%
	Сүүлийн хагас жил	4.8	982	377.0 сая	323.0 сая	54.0 сая	100%
Нийт		11.4		895.4 сая			

Тайлангаас харвал тухайн жилүүдэд тараасан ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 100 хувь тараасан байна. Ингээд өөр холбоотой асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс энэ асуудлаар санал байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

- **Хэлэлцсэн 3-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2019 оны ногдол ашгийг хуваарилж тараасан мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийг хуваарилах тухай мэдээллийг хурал оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжив.**

4. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

Хурлын дарга Д.Оюунсүрэн: “Гермес центр” ХК-ийн хувьцааны 5-аас дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийг уламжлал ёсоор танилцуулдаг. Миний бие нь өөрийн гэр бүлийн хүн болох Д.Зоригтын хамт энэ компанийн 65 990 160 ширхэг хувьцаа буюу 84.0 хувийг хамтран эзэмшиж байна. Өнгөрсөн хугацаанд эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт ороогүй, хэвээр байгаа болно.

	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр	Эрхэлж буй албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны		
			Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	Энэ хувьд хүрсэн огноо
1	Дашзэвэг овогтой Зоригт	Иргэн	42 530 145	54.15 %	2021.03.11
2	Дугаржав овогтой Оюунсүрэн	"АСУ" сургуулийн захирал	23 460 015	29.87 %	2021.03.11
Нийт			65 990 160	84.0 %	

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу.

Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт, санал байхгүй гэж хариулав.

Хурлын дарга Д.Оюунсүрэн : Асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа орцгооё.

- **Хэлэлцсэн 4-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны мэдээллийг хурлын тэмдэглэлд оруулав.**

5. Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилт. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: “Ая тухыг эрхэмлэгч” уриатай манай компани нь Гермес барилгын материалын худалдааны төвийн үйл ажиллагааг явуулахдаа

- Нэгдүгээрт : Худалдан авагчдын эрх ашгийг дээдэлж, ая тухтай үйлчилж
- Хоёрдугаарт : Түрээслэгчдийн эрх ашгийг дээдэлж, тэднийг ажиллах нөхцлөөр хангаж
- Гуравдугаарт : Ажиллагсдынхаа эрх ашгийг хамгаалж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж
- Дөрөвдүгээрт : Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж
- Тавдугаарт : Коронавирусын цар тахлын үед УИХ, ЗГ, УОК-оос баталсан түр хууль, дүрэм, журам, шийдвэрийг үндэслэн уян хатан бодлого баримталж ажиллана.

Компанийн орлогын тухай: Компани нь 2021 оны эцэст 1 874.4 сая төгрөгийн орлоготой ажиллана.

Компанийн зарлагын тухай: Компанийн хэмжээгээр 2021 онд төсөвлөснөөр 845.3 сая төгрөгийн зардалтай ажиллана.

Компанийн ашгийн тухай: Татварын дараах цэвэр ашиг төсөвлөснөөр 926.1 сая төгрөг байна.

Компанийн нэгж хувьцаанд хуваарилах ашигийн тухай: “Гермес центр” ХК-ийн нэгж хувьцаанд 11 төгрөг 79 мөнгөний ногдол ашиг оногдохоор төлөвлөсөн.

Компанийн бүтэц зохион байгуулалтын тухай: “Гермес Центр” ХК нь 16 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулна.

Та бүхэнд асуух асуулт байвал асууна уу? Маргаашнаас хатуу хөл хорио тавина гэж байгаа учраас гадуур хөл хөдөлгөөн ихтэй байна. Дараа жил бид бүгдээрээ хурлын танхимдаа өмнөх үе шигээ бие биенээ хараад хуралдана гэдэгт итгэлтэй байна. Гүйцэтгэх удирдлагын баг хичээн ажиллана.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

- **Хэлэлцсэн 5-р асуудлаар гаргасан шийдвэр :** Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилтыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжлээ.

6. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай: Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Манай “Гермес центр” хувьцаат компани нь оршин байрлах засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 4-р хороонд харьяалагддаг байсан. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 11-р сарын 22-ны өдрийн 28/28 тоот тогтоол, Баянгол дүүргийн ИТХурлын тэргүүлэгчдийн 32 тоот тогтоол гарч, тус дүүргийн 4-р хороог хоёр хувааснаар манай компани Баянгол дүүргийн 25-р хороонд харьяалагдах боллоо. Ийм учир компанийн дүрэмд оршин байрлах хаягийн өөрчлөлтийг тусгаж батлуулах шаардлагатай байна.

Дүрмийн одоогийн заалт	Дүрмийн өөрчлөлт оруулсны дараах заалт
1.4 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, өөрийн байр	1.4 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 25-р хороо, 2-р хороолол, Нарны зам 20, 20/1

Мөн дэлхий нийтэд үүсээд буй цар тахлаас үүдэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхийг хангах зорилгоор компанийн дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж батлуулах саналтай байна. Үүнд:

Дүрмийн одоогийн заалт	Дүрмийн өөрчлөлт оруулсны дараах заалт
7.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.	7.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байх бөгөөд дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд: 7.2.1 зайнаас (мэдээллийн техник, технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах) 7.2.2 хосолсон (танхим болон зайнаас)

Компанийн дүрэмд оруулах өөрчлөлттэй холбогдуулан асуух асуулт байна уу. Хувьцаа эзэмшигч М.Шигшээ таньд асуулт байна уу. Танхимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ: Асуулт алгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Зоригт : Хурлын материал ойлгомжтой, мөн өмнө нь нийтэд тараагдаж танилцсан байсан тул асуух зүйл алга байна. Хэлэлцэж байгаа асуудлуудад санал нэг байна.

Танхимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс өөр асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг дэмжиж сайшаав.

- ***Хэлэлцсэн 6-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг батлах тогтоолын төслийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.***

7. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай: Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Энэ асуудлыг компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга Б.Оюунцэцэг миний өмнөөс танилцуулна уу. Хоолой ирвэгнээд ярихад жаахан хүндрэлтэй байгаа тул та бүхнээсээ хүлцэл өчье.

Нэр дэвшүүлэх хорооны дарга Б.Оюунцэцэг: Миний бие Б.Оюунцэцэг нь тус компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга албыг хашдаг. Энэ жил манай ТУЗ-ийн 2 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа юм. Компанийн тухай хуулийн 62.1.7 заалтын дагуу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн баталдаг билээ. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ын дагуу санал хураах бөгөөд дээрх журмыг 2020 оны 09-р сарын 09-ний өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан байдаг. Энэ журмаар бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тухайн 2 гишүүнийг дангаар сонгох боломжгүй болсон. Иймээс миний бие ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргын хувьд “Компанийн тухай хууль”-ийн 77.2-р зүйлийг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь улируулан сонгох саналыг гаргасан бөгөөд энэ санал 100% дэмжигдсэн. Манай компанийн үйл ажиллагаа тогтвортой сайн байгаа нь эрхэм гишүүд компанийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог, хурлын ирц оролцоо сайн байдаг, гүйцэтгэх удирдлагын багт зөв бодлого, зөв чиглэлийг байнга өгч ажилладагтай нягт холбоотой юм. Компанийн цаашдын үйл ажиллагаа зөв байхад манай ТУЗ-ийн эрхэм гишүүдийн зөв санаа бодол, идэвхи оролцоо хамгийн чухал гэдгийг бидний ажил, амьдралын туршлага харуулсаар байна. Иймд ТУЗ-ийн ердийн гишүүн болох Д.Оюунсүрэн, Б.Оюунцэцэг, Д.Алтанчимэг, Н.Мөнхзул, Ц.Түвшинжаргал, Б.Амарсанаа, хараат бус гишүүн болох Д.Туяа, Н.Батсайхан, Б.Алтангэрэл нарыг улируулан сонгох саналыг оруулж байна. ТУЗ-ийн гишүүдийн танилцуулгыг дэлгэцээр харуулна уу. Ингээд та бүхэн саналаа хэлнэ үү.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ЕРДИЙН ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Дугаржав Оюунсүрэн
2. Оршин суугаа хаяг: УБ хот, БЗД, 13-р хороо, АОС 2 тоот
3. Утас: 9111-3484
4. Е майл хаяг: managingdirector@asu.edu.mn
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1959 оны 02-р сарын 08-ний өдөр
7. Регистрийн дугаар: ЧС 59020887
8. Төгссөн сургууль: ОХУ, Москва хот, Технологийн дээд сургууль
9. Мэргэжил: Инженер эдийн засагч
10. "Гермес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн дарга
11. Улсад хэдэн жил ажилласан: 39 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	НААҮЯамны Хувцас загвар зохион бүтээх товчоо	Эдийн засагч	1982	3 жил
2	НААҮЯамны МХХэлтэс	Мэргэжилтэн	1985	4 жил
3	НААҮЯамны Агентлаг	Мэргэжилтэн	1989	3 жил
4	ХҮЯам	Мэргэжилтэн	1991	5 жил
5	ГХЯ ХХХАХ	Мэргэжилтэн	1996	6 жил
6	АСУ сургууль	Гүйцэтгэх захирал	2001	Одоог хүртэл

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ЕРДИЙН ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Батсүх Оюунцэцэг
2. Оршин суугаа хаяг: УБ хот, БЗД, 1-р хороо, 29-р байрны 20 тоот
3. Утас: 9911-3321
4. Е майл хаяг: otsetseg2004@yahoo.com
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1965 оны 05-р сарын 21 өдөр
7. Регистрийн дугаар: ХД 65052167
8. Төгссөн сургууль: ОХУ, Эрхүү хот, УАААДСургууль, ТЗУХ-ийн институт
9. Мэргэжил: Инженер эдийн засагч, Бизнесийн удирдлагын менежер
10. "Гермес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 32 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	СОТ 2 барилгын орос захиргаа	Эдийн засагч	1989-1993	4 жил
2	ТЗУдирдлагын хөгжлийн институт	Оюутан	1994-1995	1 жил
3	Монгол шуудан	Хэлтсийн захирал	1996-2009	14 жил
4	Гермес Центр ХК	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	2009-2015	6 жил
5	Гермес Центр ХК	Гүйцэтгэх захирал	2016	Одоог хүртэл

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ЕРДИЙН ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Дүвчиндорж Алтанчимэг
2. Оршин суугаа хаяг: УБ хот, БЗД, 7-р хороо, 38а-р байрны 15 тоот
3. Утас: 9985-1033
4. Е майл хаяг: altanchimeg69@yahoo.com
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1974 оны 12-р сарын 09-ний өдөр
7. Регистрийн дугаар: АЭ 74120969
8. Төгссөн сургууль: МУИСургуулийн эдийн засгийн дээд сургууль
9. Мэргэжил: Нягтлан бодогч
10. "Термес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн Ердийн гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 24 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	"Ханбүргэдэй" ХХК	Нягтлан бодогч	1997-2004	4 жил
2	"Айрлинк" ХХК	Нягтлан бодогч	2000-2006	7 жил
3	"Одод" ХХК	Нягтлан бодогч	2006	Одоог хүртэл

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ЕРДИЙН ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Намсрай Мөнхзул
2. Оршин суугаа хаяг: УБ хот, СБД, 4-р хороо, 34-р байрны 37 тоот
3. Утас: 9909-6636
4. Е майл хаяг: munkhzul61@yahoo.com
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1961 оны 10-р сарын 17 өдөр
7. Регистрийн дугаар: ТЖ 61101701
8. Төгссөн сургууль: ОХУ, Эрхүү хот, их сургууль, СЭЗДСургууль
9. Мэргэжил: Эдийн засагч
10. "Гермес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 33 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	Ургамал газар тариалангийн хүрээлэн	Ажилтан	1985-2003	18 жил
2	МШБанк	Эдийн засагч	2003-2009	6 жил
3	Хадгаламж банк	Эдийн засагч	2009-2012	3 жил
4	Төрийн банк	Эдийн засагч	2012-2016	4 жил
5	Хувийн бизнес	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	2016	Одоог хүртэл

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ЕРДИЙН ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Буянцог Амарсанаа
2. Оршин суугаа хаяг: УБ хот, БЗД, 26-р хороо, 422-32 тоот
3. Утас: 9909-5243
4. Е майл хаяг: Amaraa80@yahoo.com
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1980 оны 03-р сарын 07-ны өдөр
7. Регистрийн дугаар: ЧТ 80030779
8. Төгссөн сургууль: МУИСургууль
9. Мэргэжил: Эрх зүйч
10. "Гермес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 17 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	Монгол шуудан банк	Хуульч	2004-2009	5 жил
2	Хадгаламж банк	Хуулийн мэргэжилтэн	2009-2010	1 жил
3	Төрийн банк	Үйл ажиллагааны хяналтын хэлтсийн захирал	2010-2017	6 жил
4	Төрийн банк	Хуулийн хэлтсийн захирал	2017	Одоог хүртэл

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ЕРДИЙН ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Цээнсүрэн Түвшинжаргал
2. Оршин суугаа хаяг: УБ хот, СХД, Өнөр хороолол, 27-5-156 тоот
3. Утас: 9111-1118
4. Е майл хаяг:
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1958 оны 01-р сарын 11-ний өдөр
7. Регистрийн дугаар: ЧТ 58011133
8. Төгссөн сургууль: Дүрслэх урлагийн дээд сургууль
9. Мэргэжил: Зураач
10. "Термес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 34 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	Зоос гоёл чимэглэлийн үйлдвэр	Чулууны засалчин	1979	8 жил
2	Протезийн үйлдвэр	Мастер	1987	4 жил
3	Хувийн бизнес	Эзэн	1991	Одоог хүртэл

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Нямжав Батсайхан
2. Оршин суугаа хаяг: УБ хот, БГД, бичил хороолол, 6Б байр-29
3. Утас: 9909-2929
4. Е майл хаяг: n_nbatsaikhan@yahoo.com
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1969 оны 04-р сарын 15-ны өдөр
7. Регистрийн дугаар: ФЖ 69040518
8. Төгссөн сургууль: МУИСургууль
9. Мэргэжил: Эдийн засагч
10. "Термес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн хараат бус гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 22 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	Монгол даатгал ХХК	Даатгалын менежер	1999	5 жил
2	Монгол даатгал ХХК	Маркетингийн ажилтан	2005	4 жил
3	Монгол даатгал ХХК	Салбарын захирал	2009	Одоог хүртэл

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Балжинням Алтангэрэл
2. Оршин суугаа хаяг: ХУД, 11-р хороо, Хан хилс 530-р байр 704 тоот
3. Утас: 9911-0060
4. Е майл хаяг: altaa79@yahoo.com
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1979 оны 03-р сарын 25-ны өдөр
7. Регистрийн дугаар: ЕЙ 79032539
8. Төгссөн сургууль: СЭЗД сургууль
9. Мэргэжил: Банкны эдийн засагч
10. "Гермес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн хараат бус гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 22 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	Монгол шуудан банк	Ахлах эдийн засагч	1999-2009	10 жил
2	Хадгаламж банк	ББГ Орлогч захирал	2009-2010	1 жил
3	Арьяа ХХК	Гүйцэтгэх захирал	2011-2012	1 жил
4	Нүүдэлчин групп	Санхүүгийн захирал	2012-2015	4 жил
5	Чингис хаан банк	ББГ-ын захирал	2015-2017	2 жил
6	Ар гурван хэц ХХК, /Хан хилс төсөл/	Гүйцэтгэх захирал	2017	Одоог хүртэл

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД УЛИРУУЛАН СОНГОГДОХ ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Дашцэрэн Туяа
2. Оршин суугаа хаяг: БГД, 10-р хороолол, К-107-р байр 41 тоот
3. Утас: 9900-5810
4. Е майл хаяг: tuyaa@savingsbank.mn
5. Хүйс: Эр Эм
6. Төрсөн огноо: 1970 оны 11-р сарын 08-ний өдөр
7. Регистрийн дугаар: ГЮ 70110801
8. Төгссөн сургууль: МУИСургууль
9. Мэргэжил: Эдийн засагч
10. "Термес Центр" ХК-д ямар ажил эрхэлдэг: ТУЗ-ийн хараат бус гишүүн
11. Улсад хэдэн жил ажилласан: 29 жил
12. Хувьцаа эзэмшдэг эсэх: Тийм Үгүй
13. Ажил эрхлэлтийн байдал:



№	Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажилласан хугацаа
1	Булган аймгийн Дэвшилт сонины газар	Дэвтэрлэгч	1988	3 жил
2	Булган аймгийн ЗДТГ-т	Эдийн засагч	1995	1.4 жил
3	Ардын банк /Сэргээн босголтын банк Булган аймаг дахь салбарт/	Эдийн засагч	1996	1.8 жил
4	СББ-ны Булган аймаг дахь салбарт	Ерөнхий нягтлан бодогч	1998	1 жил
5	Монгол шуудан банк	Нягтлан бодогч, эдийн засагч	1999	10.4 жил
6	Хадгаламж банк	СТХэлтэст ахлах эдийн засагч	2010	1 жил
7	Төрийн банк	Хэлтсийн захирал	2011	Одоог хүртэл

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ: Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлд улируулан сонгогдож байгаа гишүүддээ баяр хүргэе. Миний хувьд дандаа таньдаг хүмүүс байгаа болохоор итгэж байна. Саналыг 100% дэмжиж байна. Мөн надад нэг горимын санал байна. Энэ нь компанийн үйл ажиллагааг зөв удирдан зохион байгуулахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа ТУЗ-ийн эрхэм гишүүддээ тодорхой хэмжээний урамшуулал олгож болох уу.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Таны энэхүү саналыг ТУЗ-ийн дараагийн ээлжит хуралд уламжилж танилцуулья. Баярлалаа

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ: За баярлалаа өөр асуулт алга. ТУЗ-д улиран сонгогдож буй гишүүдийнхээ цаашдын ажилд нь амжилт хүсье. Мөн зөв, оновчтой шийдвэр гаргаж хувьцаа эзэмшигчдийнхээ ногдол ашгийг нэмэгдүүлэхийн төлөө хичээн ажиллахыг та бүхнээс хүсэж байна.

Хуралд танхимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс саналыг 100% дэмжиж байгаагаа илэрхийлэв. Мөн ТУЗ-д улиран сонгогдож буй гишүүдэд баяр хүргэж, ажлын амжилт хүслээ.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: ТУЗ-д улиран сонгогдож буй эрхэм гишүүдэд баяр хүргэе.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: За баярлалаа. Миний зүгээс ч гэсэн эдгээр хүмүүстэй хамтран ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын багтаа баярлалаа гэж хэлэх нь зүйтэй. Өөр санал хэлэх хүн байна уу?

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байхгүй гэж хариулав.

- *Хэлэлцсэн 7-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар тоолж, ердийн гишүүдээр Д.Оюунсүрэн, Б.Оюунцэцэг, Д.Алтанчимэг, Б.Амарсанаа, Ц.Түвшинжаргал, Н.Мөнхзул нарыг, хараат бус гишүүдээр Н.Батсайхан, Д.Туяа, Б.Алтангэрэл нарыг сонгов.*

8. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 онд цалингийн зардалд нийт 12.8 сая төгрөгийг гаргаж зарцуулсан. ТУЗ-ийн дарга хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 410 000 төгрөг, гишүүд хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000 төгрөгийн цалин авдаг. Хуралд оролцоогүй тохиолдолд цалин олгодоггүй. Харин компанийн гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардалд нийт 74.3 сая төгрөг зарцуулсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2021 онд цалингийн санг өмнөх оны төсвөөр батлуулсан. Үүнд:

- Цалингийн нийт зардал 4 улирлаар тооцоход 12.8 сая төгрөг

Компанийн Гүйцэтгэх захирлын цалин урамшуулалд зориулан өмнөх оны мөн адил 75.0 сая төгрөгийн зардлыг гаргахаар баталсан. Компанийн гүйцэтгэх захирлын цалин урамшууллыг компанийн ТУЗ баталдаг бөгөөд Компанийн тухай хуулийн дагуу ХЭХуралд тайлагнадаг. Энэ журмын дагуу та бүхэндээ тайлагнаж байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулалтай холбоотой асуух асуулт байна уу. Асуух асуулт байхгүй бол тогтоолын төслүүдээ батлах уу?

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ: Хувьцаа эзэмшигч нартаа мөн гарын бэлэг өгдөг болвол зүгээр юм шиг санагдлаа.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Болохгүй зүйл байхгүй, дараа жилээс бид хичээнэ.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс тогтоолын төслийг 100% дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Эрдэнэсүрэн: Цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн хувьд санал хураалтын 2 линкийг чат хэсэгт байрлуулсан байгаа тул та бүхэн зааврын дагуу саналаа өгнө үү. Мөн танхимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн хувьд саналын хуудсаа бөглөөд хурлын дараа тооллогын комисст хураалгана уу. Тооллогын комисс санал хураалтын нэгдсэн дүнг гаргана.

- **Хэлэлцсэн 8-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн ТУЗ-ийн зардлын төсвийн тогтоолын төслийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.**

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Өөр асуух асуулт, санал хүсэлт байхгүй бол хурлын дэгийн дагуу өнөөдрийн хурлаа өндөрлөж байна. Хуралдаа танхимаар болон цахимаар оролцсон эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа. Цар тахлын хүнд үеийг хамтдаа даван туулцгаая.

“Гермес центр”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 2 цаг 30 мин үргэлжилж, 17 цаг 30 минутанд дуусав. Хурал амжилттай болж өнгөрлөө.



[Handwritten signature]
[Handwritten signature]

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:
..... ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:
.....ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэсүрэн